



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 375,772,826.00 (гурван зуун далан таван сая долоон зуун далан хоёр мянга найман зуун хорин зургаа) төгрөгийн балансын үнэ, 5,959,178.68 (таван сая есөн зуун тавин есөн мянга нэг зуун далан найман төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Н.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001535

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
ХТХ-дүгээр тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын балансаас "Үндэсний дата төв" УТҮГ-ын балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хөргөлтийн тоног төхөөрөмж	2020/12/09	ш	1	374,066,066.00	374,066,066.00	4,571,918.56	369,494,147.44
	ДҮН			1		375,772,826.00	5,959,178.68	369,813,647.32
						375,772,826.00 (гурван зуун далан таван сая долоон зуун далан хоёр мянга найман зуун хорин зургаа)	5,959,178.68 (таван сая есөн зуун тавин есөн мянга нэг зуун далан найман төгрөг жаран найман мөнгө)	369,813,647.32 (гурван зуун жаран есөн сая найман зуун арван гурван мянга зургаан зуун дөчин долон төгрөг гучин хоёр мөнгө)